



Г

“РЕМОН” ХХК-Д

Г

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84,
E-mail: info@frc.mn, <http://www.frc.mn>

2022.7.04 № ЦАТ-11/02/006 .
танай 2022.5.17 -ны № 4/231 -т

Г

Гүйцэтгэх захирлын өөрчлөлтийг
бүртгэсэн тухай

Г

Танай компанийн гүйцэтгэх захирлын өөрчлөлтийг бүртгүүлэх тухай хүсэлт, холбогдох баримт бичгийг Хорооны 2020 оны 120 дугаар тогтоолоор баталсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам” болон 179 дүгээр тогтоолоор баталсан “Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”-ын дагуу хянаж үзэхэд томилохоор ирүүлсэн ажилтан нь холбогдох журмын шаардлагыг хангаж байгаа тул одоогийн гүйцэтгэх захирал Ганболдын Тэмүүлэнг өөрчилж, Болдын Бүжинлхамыг Хорооны нэгдсэн бүртгэлд шинэчлэн бүртгэсэн болно.

Цаашид Хорооны 2020 оны 120 дугаар тогтоолоор баталсан журмын 6.2-т “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага нь дараах өөрчлөлтүүдийг оруулахын өмнө тухай бүр Хороонд мэдэгдэж, бүртгүүлнэ”, 6.2.1-д “үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын эрх бүхий албан тушаалтан өөрчлөгдөх” гэж заасны дагуу эрх бүхий албан тушаалтан болон брокер өөрчлөгдөх тухай бүр Хороонд бүртгүүлж ажиллахыг анхаарна уу.

